



**МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТУШААЛ**

2017 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/221

Улаанбаатар хот

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд салбар дундын зохицуулалтыг хангаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/-т даалгасугай.
3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох журмын дагуу Засгийн газарт танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т үүрэг болгосугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
сайдын 2017 оны 12 дугаар сарын 26-ны  
өдрийн 21/2021 тушаалын хавсралт



**ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
2018-2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.					
Хүрэх үр дүн	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүн амын дундаж наслалтыг 74-т хүргэх, төрөлтийн түвшинг эргэн нөхөгдөх түвшинд буюу түүнээс дээш түвшинд байлгах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана;</li> <li>2. Орон нутагт хүн тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хөдөө рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг урамшуулах замаар хөдөөгийн хүн амын нийт хүн амд эзлэх хувийг нэмэгдүүлж, хүн амын байршлын зохистой харьцааг хот, хөдөөд тэнцвэртэй болгоно;</li> <li>3. Гэр бүлийн боловсролыг хүүхэд наснаас олгох, гэр бүлийн тогтвортой харилцааг дэмжиж, амьжиргааны тогтвортой эх үүсвэртэй болгох арга хэмжээг авах замаар гэр бүлийг дэмжиж, нийгмийн дундаж давхаргыг нийт хүн амын 60 хувьд хүргэнэ;</li> <li>4. Хүн авьяас чадвараа хөгжүүлэн үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах чанартай боловсрол, мэдлэг, чадварыг эзэмших, зөв төлөвших, насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлж, тэмүүлэлтэй, хариуцлагатай, бүтээлч, хөдөлмөрч, бусдыг хүндлэх хүмүүнлэг ёс зүйтэй, амьдралын зөв дадал, хэвшилтэй, үндэсний дэвшилтэт уламжлал, өв соёлоо дээдэлсэн монгол хүнийг төлөвшүүлнэ;</li> <li>5. Эдийн засгийн өсөлтийн өгөөжийг зохистой хуваарилж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажиллах хүчний нөөцийг төлөвлөлттэйгээр үр дүнтэй ашиглах замаар хүн амыг ажилтай, орлоготой болгож, ажилгүйдлийн түвшинг 4 хувьд, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүртэл бууруулна;</li> <li>6. Нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгож, эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдах хувийг 95-д хүргэх бөгөөд ахмад настны нийгмийн баталгааг хангах, нийгмийн идэвхтэй гишүүн байх, боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.</li> </ol>					
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
<b>НЭГ. ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ ТААТАЙ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ</b>						
1.	Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн баримт бичиг</li> <li>- Дунд хугацааны болон эцсийн үнэлгээний тайлан, дүгнэлт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Батлагдсан үндэсний хөтөлбөр</li> <li>- Бодлогын суурь оны түвшинтэй харьцуулахад нялхас, 5 хүртэлх насны хүүхэд, эхийн эндэгдлийн түвшин буурсан байна.</li> </ul>	ЭМЯ <sup>1</sup>	-	2018-2025

<sup>1</sup> Эрүүл мэндийн яам

2.	Өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэнд, жендэр, гэр бүлийн боловсрол олгох асуудлыг сургалтын агуулга, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх	Сургалтын модуль, хөтөлбөр		БСШУСЯ <sup>2</sup>	НТБҮТ <sup>3</sup>	2018-2025
3.	Хүн амын ердийн хөдөлгөөний статистик тоон мэдээг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргаж, хүн ам зүйн мэдээллээр бодлого боловсруулагчдыг хангах	Батлагдсан шийдвэр	<ul style="list-style-type: none"> <li>- Иргэний бүртгэлээс гаргадаг болсон мэдээллийн тоо</li> <li>- Мэдээллийн давтамж</li> </ul>	ЭМЯ	ҮСХ <sup>4</sup> ОӨУБЕГ <sup>5</sup>	2018-2020
4.	Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Эрх зүйн баримт бичиг Хэрэгжилтийн тайлан	<ul style="list-style-type: none"> <li>- Батлагдсан эрхзүйн баримт бичиг;</li> <li>- Эрхийн бичгээр үйлчлүүлсэн хүн амын тоо;</li> </ul>	ЭМЯ	СЯ <sup>6</sup> , ХНХЯ <sup>7</sup> , ХХҮЕГ <sup>8</sup>	2018-2025
5.	БЗДХ, ХДХВ-ын нотолгоонд суурилсан, шинэлэг, хосолмол урьдчилан сэргийлэх аргуудыг нэвтрүүлэх	Нэвтрүүлсэн арга	<ul style="list-style-type: none"> <li>- Арга нэвтрэлтийн хувь</li> <li>- Шинээр нэвтрүүлсэн аргын тоо</li> </ul>	ЭМЯ	ХӨСҮТ <sup>9</sup> , Глобал сан, ТББ <sup>10</sup> -ууд	2018-2025
6.	Төр, ТББ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад БЗДХ, ХДХВ, ДОХ-ын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бий болгох	Мэдээллийн сан	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээллийн сантай болсон байна.</li> <li>- Мэдээллийн сангийн төрөл</li> </ul>	ЭМЯ	ХӨСҮТ Глобал сан, ТББ-ууд	2018-2020

<sup>2</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

<sup>3</sup> Насан туршийн боловсролын үндэсний төв

<sup>4</sup> Үндэсний статистикийн хороо

<sup>5</sup> Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар

<sup>6</sup> Сангийн яам

<sup>7</sup> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

<sup>8</sup> Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

<sup>9</sup> Халдварт өвчин судлалын үндэсний төв

<sup>10</sup> Төрийн бус байгууллага

7.	Халдварт болон халдварт бус өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>- Сурталчилгааны ажлын тайлан</li> <li>- Хамрагдсан хүний тоо</li> </ul>	ЭМЯ	ХӨСҮТ, ТББ-ууд	2018-2025
8.	НҮЭМ-ийн эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх;	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>- Охидын жирэмслэлт, төрөлтийн хувь</li> <li>- Үр хөндөлтийн хувь</li> <li>- Хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо</li> <li>- Жирэмсний үед эрт илрүүлсэн хүндрэлийн тоо</li> <li>- Гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн аргын хэрэглээний хувь</li> </ul>	ЭМЯ	ЭХЭМҮТ <sup>11</sup> , НЭМҮТ, аймаг нийслэлийн ЗДТГ <sup>12</sup> , ЭМГ <sup>13</sup> , ТББ-ууд	2018-2025
9.	Монгол хүний бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн талаар нийт хүн амыг хамарсан судалгаа явуулж, мэдээллийн нэгдсэн сан бий болгох;	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгааны үр дүнгийн тайлан</li> <li>- Судалгааны мэдээллийн сан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хамрагдалтын хувь</li> </ul>	БСШУСЯ	НЭМҮТ, БТСГ <sup>14</sup>	2020-2025
10.	Биеийн тамир, спортын талаарх хүн амын ойлголт, хандлагыг дээшлүүлэх, сонирхлыг төрүүлэх, спортоор хичээллэх, авъяасаа хөгжүүлэхэд чиглэгдсэн ТББ-уудын санаачлага, үйл ажиллагааг дэмжих	Арга хэмжээний төлөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Санаачлагын тоо</li> <li>- Дэмжлэг авсан байгууллагын тоо</li> <li>- Дэмжлэгийн төрөл, хэлбэр</li> </ul>	БСШУСЯ	БТСГ	2018-2025
11.	Бага насны хүүхэдтэй эхийн ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох талаар Хөдөлмөрийн тухай хуулинд тусгах	<ul style="list-style-type: none"> <li>- Батлагдсан хууль</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хуульд өөрчлөлт оруулах талаар хийсэн хэлэлцүүлгийн тайлан</li> </ul>	ХНХЯ	ЭМЯ	2018-2019

<sup>11</sup> Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

<sup>12</sup> Засаг даргын Тамгын газар

<sup>13</sup> Эрүүл мэндийн газар

<sup>14</sup> Биеийн тамир, спортын газар

			- Хуулийн төсөл			
12.	Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих үндэсний аяныг тогтмол зохион байгуулж, хэвших	Ажлын төлөвлөгөө, тайлан	- Эхийн сүүгээр хүүхдээ хооллодог эхчүүдийн хувь	ЭМЯ	НЭМҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ	2018-2025
13.	Зорилтот бүлгийн хүүхэд, эмэгтэйчүүдэд хүнсний хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Бодлогын шийдвэр	- Дэмжлэг авсан зорилтот бүлгийн хүүхэд, эмэгтэйчүүдийн тоо - Зарцуулсан хөрөнгө	ХНХЯ	ХХҮЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2018-2025
14.	Эрүүл зөв хооллох, мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр тогтмол явуулах;	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хөтөлбөр	- Мэдээлэл, сургалт, сурталчилгааны тайлан - Цахим мэдээлэлд хандалтын тоо	ЭМЯ	НЭМҮТ, Хэвлэл мэдээллийн байгууллагууд	2018-2025
15.	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Батлагдсан төлөвлөгөө	- Агаарын бохирдлын хувь	БОАЖЯ	Нийслэлийн ЗДТГ	2018-2025
16.	Хувь хүний эрүүл ахуй болон ариун цэвэр, ундны усны хадгалалт, хамгаалалтын талаар мэдлэг олгох сургалт, сурталчилгааг тогтмолжуулах;	Сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөө	- Мэдээлэл, сургалт, сурталчилгааны тайлан - Цахим мэдээлэлд хандалтын тоо	ЭМЯ	БОАЖЯ <sup>15</sup> , БСШУСЯ, Амаг, нийслэлийн ЗДТГ, НТБҮТ, НЭМҮТ	2018-2025
17.	Эх орондоо оношлуулах, эмчлүүлэх нөхцлийг сайжруулж, гадаад оронд эмчлүүлэх иргэдийн тоог бууруулах бодлого хэрэгжүүлэх хүрээнд олон улсын жишигт нийцсэн "Үндэсний оношилгоо, эмчилгээний төв" байгуулах	Байгуулагдсан "Үндэсний оношлогоо, эмчилгээний төв"	- Барилгын ажлын явц - Төвөөр үйлчлүүлэгчдийн тоо	ЭМЯ	-	2018-2025
18.	Оношлогоо эмчилгээний стандарт, шалгуур үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	Оношлогоо эмчилгээний стандарт	- Батлагдсан стандартын тоо - Хэрэгжилтэд хийсэн хяналтын ажлын тайлан	ЭМЯ	-	2018-2025

<sup>15</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын яам

19.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөө	- Хөтөлбөрийн хэрэгжилтийн болон ХШҮ-ний тайлан	ХНХЯ	-	2021-2025
20.	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх;	Сургалтын хөтөлбөр	- Мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүний тоо	ЭМЯ	НЭМҮТ, ЦЕГ <sup>16</sup> , ОБЕГ <sup>17</sup> , ТББ-ууд	2018-2025
21.	Аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөж байгаа дүрэм, журмыг ойлгомжтой, хялбар болгон ажилчдад хүргэх, ажлын байран дээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих, уг сургалтын зардлын тодорхой хувийг ҮОМШӨ <sup>18</sup> -ний даатгалын сангаас нөхөн олгох арга хэмжээ авах	Хуулийн өөрчлөлт	- Сургалтанд хамрагдсан хүний тоо - ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгосон санхүүжилт	ХНХЯ	ЭМНДЕГ <sup>19</sup>	2018-2025
22.	Хөгжлийн бэрхшээлийг эрт оношлох, илрүүлэх аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэх	Аргачлал баталсан шийдвэр	- Батлагдсан аргачлал - Хамрагдсан хүний тоо	ЭМЯ	ХНХЯ, ХХҮЕГ	2018-2019
23.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын төв, орон нутгийн комиссын үйл ажиллагааг тогтмолжуулж, тус комиссын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар цахим мэдээллийн сан байгуулах	Мэдээллийн сан	- Комиссын үйл ажиллагааны тайлан - Мэдээллийн сангийн хамрагдалт	ХНХЯ	ХБХЭМНХК <sup>20</sup>	2018-2025

<sup>16</sup> Цагдаагийн ерөнхий газар

<sup>17</sup> Онцгой байдлын ерөнхий газар

<sup>18</sup> Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

<sup>19</sup> Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар

<sup>20</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын комисс

24.	Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын тайлан</li> <li>- Мэдээлэл, сургалт сурталчилгааны тоо</li> <li>- Хамрагдсан хүний тоо</li> <li>- Илрүүлсэн хүний тоо</li> </ul>	ЭМЯ	ХНХЯ, АШУУИС <sup>21</sup> , ХХУЕГ	2018-2020
25.	"Монголоид", "монголизм" нэршлийг монгол хүн, монгол үндэстний нэр хүндэд сөрөг утгаар хэрэглэхгүй байх тухай асуудлыг ДЭМБ-ын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулах чиглэлээр ажиллах	ДЭМБ-аас гаргасан шийдвэр	<ul style="list-style-type: none"> <li>- Шийдвэрийн тоо</li> </ul>	ЭМЯ	-	2017-2018
26.	Хэвтрийн болон архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ахмад настныг Өрхийн эрүүл мэндийн төвийн байнгын хяналтад авч, асран сувилах тусламж үзүүлэх явуулын үйлчилгээг ахмад эмч, сувилагч, сайн дурын ажилтны оролцоотойгоор зохион байгуулах	Явуулын үйлчилгээ үзүүлэх шийдвэр	<ul style="list-style-type: none"> <li>- Явуулын үйлчилгээ үзүүлсэн тухай тайлан</li> <li>- Үйлчилгээ авсан ахмад настны тоо</li> <li>- Явуулын үйлчилгээ үзүүлсэн эмч, сувилагч, сайн дурын ажилтны тоо</li> </ul>	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЭМГ	2018-2025
27.	"Ахмад настны тухай" хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох дүрэм, журмыг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих	Дүрэм журам	<ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн хэрэгжилтийн талаар хийгдсэн хяналт-үнэлгээний тайлан</li> </ul>	ХНХЯ	МХЕГ <sup>22</sup> , ТББ	2018-2025
28.	Тамхи, архи, согтууруулах ундаа хэрэглэхээс татгалзах, сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах дадал, хэвшилд сургахад чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг эрчимжүүлэх	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүний тоо</li> <li>- Баг, хорооны дэргэд байгуулсан сайн дурын бүлгэм, багийн тоо</li> </ul>	ЭМЯ	СЭМҮТ <sup>23</sup> , Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ, Сайн дурын клубууд	2018-2025
<b>ХОЁР. ХҮН АМЫН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИСТОЙ ТҮВШИНД БАЙЛГАХ</b>						

<sup>21</sup> Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

<sup>22</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

<sup>23</sup> Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

29.	“Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөрийн хүрээнд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цахимжуулах;	Цахим бүртгэл	- Цахим бүртгэлд хамрагдсан хүний тоо	ХЗДХЯ <sup>24</sup>	ҮСХ, ОӨУБГ	2018-2019
30.	Иргэний бүртгэлийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд хууль, эрх зүйн орчинг сайжруулах ажлыг эрчимжүүлэх	Эрх зүйн баримт бичиг	- Батлагдсан дүрэм журмын тоо	ХЗДХЯ	ҮСХ, ОӨУБЕГ	2018-2020
31.	Гадаадын иргэн, харьяатын болон Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчийн бүртгэл, мэдээллийг шинэчлэн мэдээллийн сан бүрдүүлэх	Мэдээллийн сан	- Хилээр орсон гарсан хүний тоо - Мэдээллийн санд орсон гадаадын иргэн, харьяатын тоо	ХЗДХЯ	ХХЕГ <sup>25</sup> , ГИХГ <sup>26</sup>	2018-2020
32.	Хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн шинэчлэлийг тогтмолжуулах, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, сангийн ашиглалтыг нэмэгдүүлэх	Мэдээллийн нэгдсэн сан	- Холбогдох шийдвэр - Ажлын тайлан	ҮСХ	ОӨУБГ	2018-2025
33.	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	- Үйл ажиллагааны төлөвлөгөө - Хэрэгжилтийн тайлан	БХБЯ <sup>27</sup>	ЗГХЭГ <sup>28</sup> ХЗДХЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ	2018-2020
34.	Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандарт боловсруулах	Стандарт	- Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо, тайлан	БХБЯ	БОАЖЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ МХЕГ	2020-2025
35.	Нийслэл, дүүргийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, мод тарих ажлыг хэвшүүлэх	Байгуулсан ногоон байгууламж	- Хот, суурин газрын ногоон байгууламжийн талбайн эзлэх хувь	Аймаг, нийслэлийн ЗДТГ	БОАЖЯ БХБЯ	2018-2025
36.	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачлагад түшиглэн ногоон байгууламжийг	Байгуулсан ногоон байгууламж	- Үйл ажиллагааны тайлан	Аймаг, нийслэлийн ЗДТГ	БОАЖЯ БХБЯ	2018-2025

<sup>24</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам

<sup>25</sup> Хил хамгаалах ерөнхий газар

<sup>26</sup> Гадаадын иргэн, харьяатын газар

<sup>27</sup> Барилга, хот байгуулалтын яам

<sup>28</sup> Засгийн газрын хэрэг эрхлэх газар

	нэмэгдүүлэх хөдөлгөөн өрнүүлэх, санаачлагыг дэмжин урамшуулах		- Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ - Санаачлагын тоо				
37.	Газар тариалангийн салбарт лизингийн үйлчилгээг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	Журам	- Лизингэд хамрагдалт	ХХААХҮЯ <sup>29</sup>	-		2018-2025
38.	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжих	Бодлого/журам	- Санхүүжүүлсэн төслийн тоо	ХХААХҮЯ	-		2018-2025
39.	"Малжуулах", "Монгол малчин", "Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах" хөтөлбөрийн хүрээнд залуу, туслах малчдад дэмжлэг үзүүлэх	Хөтөлбөр	- Хөтөлбөрт хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө - Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	ХНХЯ ХХААХҮЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ		2018-2025
40.	Малчид, үйлдвэр эрхлэгчдийн шууд харилцааг дэмжих, биржийн сүлжээг байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулах	Байгуулагдсан бирж, сүлжээ	- Биржийн тоо - Борлуулалтын мэдээ, тайлан	ХХААХҮЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ		2018-2025
41.	Малчид, хөдөөгийн орлого багатай өрхийн ногоон үйлдвэрлэл эрхлэх үр чадварыг дээшлүүлж, хөнгөлөлттэй зээл, урамшууллын бодлогоор дэмжих	Бодлого, хөтөлбөр	- Хамрагдсан хүний тоо - Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан	ХХААХҮЯ	ХНХЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ		2018-2020
42.	Алслагдсан орон нутагт явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ тогтмол зохион байгуулах	Явуулын тусламж үзүүлэх шийдвэр	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо - Хамрагдсан иргэдийн тоо	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ ЭМГ		2018-2025
43.	Хөдөө орон нутагт ажиллахаар очсон багш, эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх	Хөтөлбөр, удирдамж	- Хөдөө орон нутагт өөрийн санаачлагаар ажиллаж буй багш, эмч, мэргэжилтний тоо; - Хөнгөлөлттэй нөхцөлтэй байр орон сууцаар хангагдсан	Аймаг, нийслэлийн ЗДТГ ЭМГ БССГ <sup>30</sup>	ЭМЯ, БСШУСЯ		2018-2025

<sup>29</sup> Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

<sup>30</sup> Боловсрол, соёл, спортын газар

			багш, эмч, мэргэжилтний тоо; - Олгосон урамшуул- лын хэмжээ;			
44.	Хөдөөгийн хүн амд үзүүлэх нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах талаар тусгайлсан төсөл, хөтөлбөрийг бүс нутгийн онцлог байдлыг харгалзан боловсруулж, хэрэгжүүлэх;	Төсөл	- Төсөл хөтөлбөрийн тоо - Хөтөлбөр хэрэгжүүлсэн аймаг, сумдын тоо - Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	ХХААХҮЯ	ЭМЯ	2018-2025
45.	МАА-н бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх үүднээс малчид, эмэгтэйчүүдийн бүлэг, хоршоо байгуулан боловсруулах үйлдвэрлэл эрхлэхийг дэмжих	Байгуулагдсан бүлэг, хоршоо	- Дэмжлэг авсан малчид, эмэгтэйчүүдийн бүлэг, хоршооны тоо - Дэмжлэгийн төрөл, мөнгөн дүн	ХХААХҮЯ, ХНХЯ	СЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ	2018-2025
46.	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга чадвар, мэдлэг олгох, мэдээлэл сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Сургалт, сурталчилгааны ажлын хөтөлбөр	- Сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүний тоо	Аймаг, нийслэлийн ЗДТГ БСШУСЯ	БОАЖЯ, НТБҮТ	2018-2025
47.	Нийслэл, хүн ам нь хэт төвлөрсөн суурин газраас сум, дагуул хот, тосгон руу шилжин суурьшихад дэмжлэг үзүүлэх журам боловсруулан хэрэгжүүлэх;	Журам	- Журмын дагуу шилжин суурьшсан хүний тоо - Журмын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний тайлан	БХБЯ Нийслэлийн ЗДТГ	ХНХЯ Аймгийн ЗДТГ	2018-2025
48.	Гадаадын иргэдэд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох ажилд тавих дотоод хяналтыг сайжруулах, тогтмолжуулах;	Хяналт шалгалтын тайлан	- Үзлэг хяналтын ажлын тоо - Тайлан мэдээ	ХНХЯ	ХХҮЕГ, МХЕГ, ГИХГ	2018-2025
49.	Хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа монголын иргэдийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох;	Мэдээллийн сан	- Мэдээллийн санд бүртгүүлсэн иргэдийн тоо	ГХЯ <sup>31</sup>	-	2018-2020
50.	Хилийн чанадад ажиллаж буй иргэн тухайн улсад төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг	Хэлэлцээр	- Хоёр талын хэлэлцээр хийсэн улс орнуудын тоо	ХНХЯ	ГХЯ	2018-2020

<sup>31</sup> Гадаад харилцааны яам

	Монгол Улсад төлсөнтэй адилтган тооцох талаар хоёр талын хэлэлцээр байгуулах ажлыг үргэлжлүүлэх		- Төлсөн НДШ-ий хэмжээ			
51.	Гадаадад их, дээд сургууль төгсөгчдийг ажлын байраар хангасан үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгох	Хууль тогтоомж, холбогдох шийдвэр	- Хууль тогтоомжид тусгах санал	ХНХЯ	ГХЯ, БСШУСЯ	2018-2025
52.	Гадаадад их, дээд сургууль төгсөгчдөд зориулсан хөдөлмөрийн яармагийг тогтмол зохион байгуулах	Хөдөлмөрийн яармаг	- Яармагт хамрагдсан болон ажилд зуучлагдсан иргэдийн тоо	ХНХЯ	ГХЯ, БСШУСЯ	2018-2025
53.	"Зөгийн үүр" хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх	Хөтөлбөр	- Боловсруулсан хөтөлбөр - Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээний тайлан	ХНХЯ	ГХЯ	2018-2025
<b>ГУРАВ. ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ, АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ</b>						
54.	Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгад гэр бүлийн боловсрол олгох асуудлыг тусгах	Хичээлийн хөтөлбөр	- Хичээлийн цаг/кредит - Суралцагчдын тоо	БСШУСЯ	ХНХЯ, НТБҮТ, ГБХЗХГ <sup>32</sup> , ТББ-ууд	2019-2022
55.	Гэр бүлийн амьдралд бэлтгэх, гэр бүлийн талаар зөв үзэл хандлага, дадал, мэдлэгтэй иргэн болгож төлөвшүүлэх бүх төрлийн мэдээлэл, сургалт, судалгааны ажлыг эрчимжүүлэх	Сургалтын хөтөлбөр Судалгааны тайлан	- Гэр бүлийн боловсрол олгох агуулгыг тусгасан хичээлийн тоо - Хичээлийг судалсан суралцагчийн тоо - Хийсэн судалгааны тоо	ХНХЯ	ГБХЗХГ, НТБҮТ, ТББ-ууд	2018-2025
56.	Шинжлэх ухааны үндэслэлтэй шаталсан сургалтаар гэр бүлийн боловсрол олгож буй гадаад орнуудын туршлага судлах, нэвтрүүлэх	Туршлагыг эх орондоо нэвтрүүлэх санал	- Туршлагын судалсан тайлан - Туршлагыг ашиглаж буй аймаг, дүүрэг, байгууллагын тоо	ХНХЯ	ГБХЗХГ, НТБҮТ ТББ-ууд	2018-2025

<sup>32</sup> Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

57.	Цус ойртох, архидан согтуурах, мансуурах зэрэг монгол хүний удмын санд сөрөг нөлөөлөх бүхнээс сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй сурталчлах эрх зүйн орчин бүрдүүлэх	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл, сурталчилгаа хийсэн хэвлэл мэдээллийн байгууллагын тоо</li> <li>- Сургалтад хамрагдсан хүний тоо</li> </ul>	ХНХЯ	ЭМЯ, ГБХЗХГ, ТББ-ууд, Хэвлэл мэдээллийн байгууллагууд	2020-2025
58.	Хүн амын доторх удамшлын өвчин, согог, оюун ухааны хомсдлын тархалт, илрэлийн талаар тандалт судалгаа хийж, зөвлөмж чиглэл гарган хэрэгжүүлэх	Судалгааны тайлан Зөвлөмж	<ul style="list-style-type: none"> <li>- Хийсэн судалгааны тоо</li> <li>- Зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан</li> </ul>	ЭМЯ	ХНХЯ ГБХЗХГ НЭМҮТ	2020-2022
59.	Үр хүүхдээ эсэн мэнд бойжуулж, нийгэмд нэр төртэй иргэн бэлтгэж өгсөн гэр бүлийн туршлагыг төрийн бус байгууллагуудтай хамтран нийтэд сурталчлан алдаршуулах ажлыг зохион байгуулах, дэмжих	Сурталчилгааны ажлын хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>- Зохион байгуулсан арга хэмжээний тоо</li> <li>- Хамрагдсан гэр бүлийн тоо</li> </ul>	Аймаг, нийслэлийн ЗДТГ ХНХЯ	ГБХЗХГ, ТББ-ууд	2018-2025
60.	Гэр бүлийн хүрээн дэх жендэрийн тэгш байдлын судалгааг 2 жил тутам явуулах;	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгааны тайлан, дүгнэлт</li> <li>- Судалгааны мэдээллийн сан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгааны тоо</li> <li>- Судалгааны зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, арга хэмжээ</li> </ul>	ХНХЯ	ГБХЗХГ	2019-2025
61.	Хүүхдийн эрхийн, Гэр бүлийн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргах;	Хөндлөнгийн үнэлгээний тайлан	<ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээнд хамрагдсан хуулийн тоо</li> <li>- Үнэлгээний ажлын зөвлөмж</li> </ul>	ХНХЯ	ХНХЯ, ГБХЗХГ ТББ-ууд	2020-2025
62.	Хүчирхийлэл үйлдэгдэх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх тогтолцоо (мэдээлэх үүрэг, эрхзүйн хамгаалалт гэх мэт)-г бий болгох, нэвтрүүлэх	Тогтолцоо	<ul style="list-style-type: none"> <li>- Энэ асуудлыг тусгасан хууль, эрх зүйн баримт бичгийн тоо</li> <li>- Хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэгт оруулсан өөрчлөлт</li> </ul>	ХЗДХЯ	ХНХЯ ГБХЗХГ	2018-2025

63.	Шинээр гэр бүл болж буй хосуудад гэр бүлийн үнэ цэнэ, хариуцлагатай, тогтвортой гэр бүлийг төлөвшүүлэхэд чиглэсэн зөвлөгөө, зөвлөмж өгөх, сургалт зохион байгуулах	Гарын авлага	<ul style="list-style-type: none"> <li>- Зөвлөгөө авсан гэр бүлийн тоо</li> <li>- Зохион байгуулсан сургалт, хамрагдсан гэр бүл</li> </ul>	ХНХЯ	ГБХЗХГ, ОӨУБЕГ Гэрлэх ёслолын ордон, ТББ-ууд	2018-2025
64.	“Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг жил бүр тогтмол тэмдэглэх	Тайлан	<ul style="list-style-type: none"> <li>- Арга хэмжээний төлөвлөгөө</li> <li>- Хэрэгжилтийн тайлан</li> </ul>	ХНХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	ГБХЗХГ, ТББ-ууд,	2018-2025
65.	Гэр бүлийн харилцааны талаар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг өргөжүүлэх, дэмжих;	Үйл ажиллагааны тайлан	<ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвийн тоо</li> <li>- Үйлчлүүлсэн хүний тоо</li> </ul>	ХНХЯ аймаг, нийслэлийн ЗДТГ	ГБХЗХГ, ТББ-ууд	2018-2025
66.	Хүн ам, ялангуяа, залуучуудын орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлөөр орон сууц худалдан авах, түрээслэх, зорилтот бүлгийн залуучууд, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>- Орон сууц худалдан авсан өрх, залуучууд, зорилтот өрхийн тоо</li> <li>- Түрээсийн орон сууцанд орсон өрх, залуучууд, зорилтот өрхийн тоо</li> </ul>	БХБЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	2018-2025
67.	Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд туслах түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах	Түр хамгаалах байр Нэг цэгийн үйлчилгээний төв	<ul style="list-style-type: none"> <li>- Түр хамгаалах байрны тоо</li> <li>- Нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо</li> </ul>	ХЗДХЯ	ХНХЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ	2018-2025
68.	Олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өрх толгойлсон эцэг, эх, ганц бие ахмад настныг дэмжих эрхзүйн орчинг боловсронгуй болгох	Хууль, бодлого, хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>- Хамрагдсан хүн/өрхийн тоо</li> <li>- Зарцуулсан хөрөнгө</li> </ul>	ХНХЯ	СЯ ХХҮЕГ ГБХЗХГ	2018-2020
69.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих;	Тайлан	<ul style="list-style-type: none"> <li>- Үйл ажиллагааны төлөвлөгөө</li> <li>- Зарцуулсан хөрөнгө</li> </ul>	ХНХЯ	Төрийн аудитын газар, ТББ-ууд	2018-2025
70.	АХБ-ны санхүүжилтээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийг хэрэгжүүлэх	Төслийн баримт бичиг Төсөл хэрэгжүүлэх нэгж	<ul style="list-style-type: none"> <li>- Үйл ажиллагааны төлөвлөгөө</li> <li>- Зарцуулсан хөрөнгө</li> </ul>	ХНХЯ	Орон тооны бус салбар зөвлөл	2018-2025
71.	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээг хангахад чиглэсэн стандартыг батлан хэрэгжүүлж,	Стандарт	<ul style="list-style-type: none"> <li>- Батлагдсан стандартын тоо</li> </ul>	ХНХЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ ХХҮЕГ	2019-2025

	шаардлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх		- Хөрөнгө оруулалтын хэмжээ	ЗТХЯ <sup>33</sup> СЯ		
<b>ДӨРӨВ. ХҮН БҮР БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ, ХӨГЖИХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ</b>						
72.	Хүүхдийг хөгжүүлэх арга зүй, технологи, хүүхдийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулах	Батлагдсан арга зүй, шалгуур үзүүлэлт	- Арга зүй, шалгуур үзүүлэлтийг баталсан шийдвэр	БСШУСЯ	ХНХЯ ГБХЗХГ	2019-2020
73.	Төв, орон нутгийн Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бэхжүүлэх	Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө	- Зарцуулсан хөрөнгө - Зохион байгуулсан сургалтын тоо; - Сургалтад хамрагдагсдын тоо; - Сургалтын дараах ур чадварын үнэлгээ	БСШУСЯ	НТБҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ БССГ	2018-2025
74.	Насан туршийн боловсролыг дэмжих, санхүүжүүлэх эрхзүйн орчинг бүрдүүлэх	Хууль/ хөтөлбөр	- Хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт - Батлагдсан хөтөлбөр	БСШУСЯ	СЯ, НТБҮТ	2018-2025
75.	"Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувийг нэмэгдүүлэх	Хөтөлбөр	- Ашиглалтад оруулах цэцэрлэгийн тоо – 12 - Шинээр байгуулах байгууллагын цэцэрлэгийн тоо – 10 - Хамран сургалтын бохир жин – 79.2%	БСШУСЯ	-	2018-2025
76.	Бүх шатны боловсролын байгууллагад, сургалтын технологи, сурах бичиг, бусад хэрэглэгдэхүүнийг ашиглаж, холбогдох стандарт шаардлагыг тогтвортой мөрдөж байгаа эсэхэд чанар, үр дүнгийн үнэлгээг тогтмол явуулах	Тайлан	- Хийсэн хяналт үнэлгээний ажлын тайлан - Хяналт, үнэлгээний дүн, дүгнэлт	БСШУСЯ	-	2018-2025
77.	Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн бакалаврын зэрэг (IB) олгох ерөнхий боловсролын сургууль байгуулахыг дэмжих	Сургууль	- Байгуулагдсан сургуулийн тоо	БСШУСЯ	-	2018-2025
78.	Бага, дунд боловсролын багш мэргэжлээр амжилттай суралцагчдад тэтгэж олгох, орон	Журам	- Тэтгэлэг авсан суралцагчдын тоо	БСШУСЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	2018-2025

<sup>33</sup> Зам тээврийн хөгжлийн яам

	нутагт очиж ажиллахыг дэмжин урамшуулах		- Тэтгэлэгт зарцуулсан хөрөнгө			
79.	Хүүхэд, залуучуудад эх орон, ард түмнийхээ түүх, соёлоор бахархах үзэл, үндэсний соёлыг дээдлэх, байгаль хамгаалах уламжлалт ёс заншлаа өвлүүлэх, сурталчлах	Сурталчилгааны хөтөлбөр	- Хэвлэл мэдээллээр явуулсан цуврал нэвтрүүлэг, уран бүтээлийн тоо; - Зохион байгуулсан сурталчилгааны тоо;	БСШУСЯ	Хэвлэл мэдээллийн байгууллагууд	2018-2025
80.	Үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн түүхэн сэдэвт бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх	Журам	- Зарцуулсан хөрөнгө - Дэмжлэг авсан бүтээлийн тоо	БСШУСЯ	-	2018-2025
81.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг нийслэл болон сонгогдсон аймагт шинээр байгуулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв	- Байгуулагдсан төвийн тоо - Төвийн үйл ажиллагааны тайлан	ХНХЯ	ЭМЯ, ХБИ-ийн ТББ	2018-2025
82.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын орчинг бүрдүүлж, хөтөлбөр, стандартыг боловсруулан мөрдөх	Хөтөлбөр, стандарт	- Зохион байгуулсан сургалтын тоо - Сургалтын тайлан	БСШУСЯ	ХНХЯ, НТБҮТ ХХҮЕГ ХБИ-ийн ТББ	2018-2025
83.	Ерөнхий боловсролын сургуулийн дугуйлан, секцийг авьяаслаг иргэдээр удирдуулах, секц, дугуйлан хичээллүүлсэн багшид нэмэлт хөлс тооцож олгох эрх зүйн орчин бүрдүүлэх	Журам	- Секц, дугуйлангийн тоо; - Батлагдсан журмын дагуу зарцуулсан хөрөнгө - Нэмэгдэл хөлс авсан хүний тоо	БСШУСЯ	БССГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ	2018-2025
84.	Насан туршийн боловсролын талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны хөтөлбөр	- Зохион байгуулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны тоо - Хамрагдсан хүний тоо	БСШУСЯ	НТБҮТ	2018-2025
85.	Дээд болон мэргэжлийн боловсролын сургуулиудын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулах ажлыг эрчимжүүлэх	Магадлан итгэмжлэл	- Ажлын төлөвлөгөө - Олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	БСШУСЯ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага	2018-2025

86.	Их дээд болон мэргэжлийн боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн уялдааны талаар судалгаа хийх	Судалгааны тайлан	- Судалгаанд хамрагдсан сургуулийн тоо	ХНХЯ БСШУСЯ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага	2018-2020
87.	Хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд олгох хөдөлмөр эрх лэлтийн сургалт болон үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр	- Хөдөлмөр эрхлэлтэд хамрагдах болон үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдах хүний тоо - 5000	ХНХЯ	-	2018-2025
88.	Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Үндэсний хөтөлбөр	- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө - Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан	ХНХЯ	ХХҮЕГ Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага	2019-2025
89.	Ахмад настанд зориулан чөлөөт цагийн танхим, мэдээллийн төвийг ажиллуулан ахмад настанд сэтгэл зүйн болон бусад зөвлөгөө өгөх	Чөлөөт цагийн танхим, мэдээллийн төв	- Байнгын ажиллагаатай ахмадууд зориулсан танхим, мэдээллийн төвийн тоо - Үйлчлүүлсэн ахмадын тоо	ХНХЯ	ХХҮЕГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ	2018-2025
90.	Ахмад настнуудын сайн туршлагыг судлах, дэмжих, нэвтрүүлэх санал санаачлагыг дэмжих, хэрэгжүүлэх	Тайлан	- Дэмжлэг авсан санаачлагын тоо, төрөл	ХНХЯ	ХХҮЕГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ	2018-2025
91.	Ахмад настны сайн дурын болон үүсгэл санаачлагын байгууллага, настанд үйлчлэх төв, настны хөгжлийн төв, клуб зэрэг төрөл бүрийн байгууллагуудын талаар олон улсын туршлагыг судалж, өөрийн оронд боломжит хэлбэрүүдийг нутагшуулах ажлыг зохион байгуулах, дэмжих	Ахмад настны сайн дурын болон үүсгэл санаачлагын байгууллага, настанд үйлчлэх төв, настны хөгжлийн төв, клуб	- Туршлага судалсан талаар тайлан илтгэл; - Байгуулсан төв, клубын тоо	ХНХЯ	ХХҮЕГ Аймаг, нийслэлийн ЗДТГ	2018-2025
<b>ТАВ. ХҮН АМЫГ АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ БАЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ</b>						
92.	Ажилгүй иргэдийн хэрэгцээ, чадвар, онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөр	- Хэрэгжүүлсэн хөтөлбөрийн тоо - Хамрагдсан хүний тоо	ХНХЯ	ХХҮЕГ	2018-2025

			<ul style="list-style-type: none"> <li>- Шинээр бий болгосон ажлын байрны тоо</li> <li>- Зарцуулсан хөрөнгө</li> </ul>			
93.	Энтрепрёнер сэтгэлгээ, гарааны бизнесийн талаар сургалт явуулах үйл ажиллагааг дэмжих	Сургалтын хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>- Дэмжлэгийн төрөл, хэлбэр</li> <li>- Энтрепрёнер сэтгэлгээ, гарааны бизнесийн талаар зөв мэдлэг, мэдээлэл авсан хүүхэд, залуучуудын хувь</li> </ul>	ХНХЯ	-	2018-2025
94.	Оюутан залуучуудыг хөдөлмөрийн харилцаанд ороход бэлтгэх, нэмэлт орлоготой болоход дэмжлэг үзүүлэх	Хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>- Цагийн болон байнгын ажлын байртай оюутны тоо</li> </ul>	БСШУСЯ	ХНХЯ, Их дээд сургуулиуд	2018-2025
95.	Төрийн албаны албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэх замаар цалинг нэмэгдүүлэх	Ангилал зэрэглэлийг шинэчилж баталсан шийдвэр	<ul style="list-style-type: none"> <li>- Шинэчлэгдсэн ангилал зэрэглэлийн тоо</li> <li>- Үйл ажиллагааны тайлан</li> </ul>	ХНХЯ	-	2018-2025
96.	Үр дүнд суурилсан үнэлгээний системийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх	Үнэлгээний системийг шинэчилсэн шийдвэр	<ul style="list-style-type: none"> <li>- Шинэ төрлийн систем нэвтрүүлсэн байгууллагын тоо</li> </ul>	ХНХЯ	СЯ	2018-2025
97.	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийг хэрэгжүүлэх	Төсөл	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийн хэрэгжилтийн болон ХШҮ-ний тайлан</li> <li>- Зарцуулсан хөрөнгө</li> <li>- Үр шимийг нь хүртсэн ХБИ-ний тоо</li> </ul>	ХНХЯ	ХБИ-ний ТББ	2018-2025
98.	Орлого багатай хөдөөгийн эмэгтэйчүүдийн бүлгүүдэд бизнес эрхлэх ур чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтад хамрагдсан хүний тоо</li> <li>- Зарцуулсан хөрөнгө</li> </ul>	ХНХЯ	ХХҮЕГ ТББ	2018-2025
99.	Эмэгтэйчүүдийг зайнаас захиалгат ажил, үйлчилгээ гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх эрхзүйн орчинг бий болгох	Батлагдсан эрх зүйн баримт бичиг	<ul style="list-style-type: none"> <li>- Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо</li> <li>- Тайлан</li> </ul>	ХНХЯ	ХХҮЕГ Эмэгтэйчүүдийн ТББ-ууд	2019-2020
100.	Орон гэргүй, тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх чиглэлээр	Хамтран ажиллах гэрээ	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэгжилтийн тайлан</li> </ul>	ХНХЯ	Нийслэлийн ЗДТГ	2018-2025

	холбогдох байгууллагатай хамтран ажиллах		- Хамрагдсан хүний тоо			
101.	Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	Үйл ажиллагааны төлөвлөгөө	- Хэрэгжилтийн тайлан болон ХШҮ-ний тайлан - Хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоо - Хөгжлийн түвшин ахисан өрхийн тоо	ХНХЯ	ХХҮЕГ Аймаг, нийслэлийн ЗДТГ	2018-2020
102.	Өрхийн орлого, зарлага, ядуурлын түвшинг тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсронгуй болгох	Батлагдсан аргачлал	- Шинэчлэгдсэн шалгуур үзүүлэлт, аргачлал	ҮСХ	СЯ, ХНХЯ	2018-2019
103.	ООТА-аар амьжиргааны түвшин тогтоох судалгааны үр дүнд үндэслэн нийгмийн халамжид хамрагдагсдыг оновчтой тогтоон, шаардлагатай үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах	Нийгмийн халамжид хамруулах шийдвэр	- Нийгмийн халамжид хамрагдсан хүний тоо - Хамрагдсан арга хэмжээний тоо - Зарцуулсан хөрөнгө	ХНХЯ	ХХҮЕГ	2018-2025
<b>ЗУРГАА. ХҮН АМЫН ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ НАСЖИЛТЫГ ДЭМЖИХ</b>						
104.	Насжилтын асуудлаарх үндэсний стратегид үнэлгээ хийж, шинэчлэн боловсруулах	Батлагдсан стратеги	- Үнэлгээний тайлан - Шинэчлэн баталсан шийдвэр	ХНХЯ	ЭМЯ	2018-2019
105.	Ахмад настны ур чадвар, туршлагыг залуу үед өвлүүлэхэд дэмжлэг үзүүлж, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Төсөл	- Хэрэгжүүлсэн нийт төслийн тоо; - Төсөлд хамрагдсан ахмад мэргэжилтний тоо; - Ахмад мэргэжилтний зөвлөх багийн тоо; - Үзүүлсэн үйлчилгээний тайлан	ХНХЯ	Ахмадын ТББ	2018-2025
106.	Ахмад настанд зөв хооллолт, дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Үйл ажиллагааны төлөвлөгөө	- Зохион байгуулагдсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны тоо;	ЭМЯ	БСШУСЯ, НЭМҮТ, Геронтологийн үндэсний төв, ТББ-ууд	2018-2025
107.	Орон нутагт ахмад настанд зориулсан явуулын урьдчилсан сэргийлэх үзлэг зохион байгуулах	Үйл ажиллагааны төлөвлөгөө	- Явуулын үзлэгийн тоо - Хамрагдсан хүний тоо	ЭМЯ	Аймаг, дүүргийн ЭМТ Геронтологийн үндэсний төв	2018-2025

108.	Эрүүл насжилт, настны эрүүл мэндтэй холбоотой хууль эрх зүйн орчны үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулах	Үнэлгээний тайлан	- Үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж	ЭМЯ	Геронтологийн үндэсний төв	2018-2025
109.	Тэтгэвэрт гарахын өмнө болон гарсны дараа өөрийн мэргэжил, чадварт тохирсон ажил эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, холбогдох сургалтад хамруулах	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө	- Сургалтын тоо - Хамрагдагсдын тоо	ЭМЯ	Геронтологийн үндэсний төв	2018-2025

--oOo--